

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 04-р сарын 15-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас тус тус баталсан холбогдох журмууд болон “Сүү” ХК-ийн Дүрмийг тус тус удирдлага болгон явууллаа.

Хурлын цаг: 15:00-17:30,

Хурлын байршил: “Сүү” ХК-ийн Хурлын танхим,

Хурлын дарга: Д.Ганбаатар,

Хурлын нарийн бичгийн дарга: Б.Цэрэндорж,

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

- Д.Ганбаатар, Б.Түвшинтөгс, Д.Жамъян, Б.Гантулга, БиДиСЕК ХК-ийн төлөөлөгч Г.Мөнхтулга, Н.Дуламжав, Г.Алтансүх, Д.Уранбилэг, А.Чулуун, С.Нямсүрэн, П.Чулуунтулга, Impera Mongolia Holding LTD-ийн төлөөлөгч Philip Khougy, Стандарт Инвестмент ҮЦК-ийн төлөөлөгч Б.Эрдэнэжаргал, Л.Түвшинжаргал,

Хурлын ирц: 329,753 ширхэг- 95,9%

Хуралд урилгаар оролцсон хүмүүс:

- ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ш.Даваалимбэ,
- Тооллогын комиссын гишүүн Д.Батзаяа,
- Азия пасифик секьюритис ХХК-ийн төлөөлөгч Ж.Нямханд,

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. Компанийн хувьцааг хуваах тухай асуудал,
3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,
5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. Компанийн хувьцааг хуваах тухай асуудал,
3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,
5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,

Танилцуулсан нь:**Нарийн бичгийн дарга:**

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Сүү” ХК-ийн 2016 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна.

Та бүхэд ээлжит хурлын ирцийн мэдээг танилцуулая.

“Сүү” ХК-ийн саналын эрх бүхий нийт 344,000 ширхэг хувьцааны 95,9% болох нийт 329,753 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн байгаа бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн байх тул хурлын ирц бүрдсэн байна.

Нарийн бичгийн дарга: Та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 03-р сарын 04-ний өдрийн № 04 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын дагуу батлагдсан хуралдааны дэгийг танилцуулая.

- Хуралдааны дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг баталсны дагуу бид энэ удаагийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж батлах ёстой байгаа. Үүнд:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. Компанийн хувьцааг хуваах тухай асуудал,
3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,
5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,

Иймд хэлэлцэх эхний асуудлын дагуу “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар танилцуулга хийх байгаа. Танилцуулга хийсний дараагаар та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой асуух зүйлс байвал асууж болно.

- “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийн талаар танилцуулга хийв.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Н.Дуламжав: Санхүүгийн тайлангаас харахад бүтээгдэхүүний өртөг өссөн дүнтэй харагдаж байна. Ийнхүү өсөх болсон шалтгаан нь юу вэ?

Б.Гантулга: 2015 оны хувь сүү бэлтгэн нийлүүлэх гол бүс нутгуудаар гантай жил байсантай холбоотойгоор сүүний гарц бага, үнэ нь өндөр байсан. Энэхүү шалтгаан нь бүтээгдээгдэхүүний өртөг өсөх шалтгаан болсон.

Б.Эрдэнэжаргал: Шинээр байгуулагдсан үнээний ферм дээр хэдэн үнээ байгаа вэ?

Б.Гантулга: Анх авчирсан 300 үнээн дээр 200 гаран тугал нэмэгдсэн байгаа. 2015 онд үнээ болон тугалын хорогдол 40 орчим гарсан байгаа.

С.Нямсүрэн: Цөцгийн тосыг Япон улсруу экспортлох асуудал яригдаж байсан. Энэ асуудал ямар шатандаа яваа вэ?

Б.Гантулга: Японы талтай ярилцаж байгаа. Гэхдээ одоогийн нөхцөл байдалд бол цөцгийн тос дотоодын зах зээлд хомсдолтой байгаа болохоор цөцгийн тосны нийлүүлэлт, гарц нэмэгдэхийг харгалзаж үзэж байна.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол хэлэлцэж байгаа эхний асуудалд саналын хуудсаар саналаа өгцгөөнө үү.

Нарийн бичгийн дарга: Та бүхэнд саналын хуудасны загварыг танилцуулая.

**“СҮҮ” ХК-ИЙН “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д САНАЛ АВАХ ХУУДАС**

“Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал” 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 15:00 цагт “Сүү” ХК-ийн байранд болов.

Хувьцаа эзэмшигчийн овог:.....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:.....

Регистрийн дугаар:.....

Санал өгөх хувьцааны тоо:.....

Бүртгэсэн: /Үнэт цаасны компанийн нэр/.....

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн саналын тоо	Татгалзсан саналын тоо
1.	2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ		

Хувьцаа эзэмшигч:...../...../

Санал авах хуудсыг ашиглах санамж:

Санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

Санал авах хуудсыг хүчингүй болгосон

шалтгаан:.....
.....

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд: Саналын хуудсаар саналаа өгөв.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу хэлэлцэх 2 дугаар асуудалдаа оръё. Дараагийн хэлэлцэх асуудал бол 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдын ээлжит бус хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн боловч, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-иас ирүүлсэн мэдэгдлийн дагуу энэхүү хурлаар дахин хэлэлцэж шийдвэрлэхээр болсон компанийн хувьцааг хуваах тухай асуудал байгаа. Хувьцаа хуваах тогтоолын төсөл болон хувьцаа хуваах төсөл зэрэг холбогдох бусад баримт бичгийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Б.Гантулга: “Сүү” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 344,000 ширхэг энгийн хувьцааны нэрлэсэн үнэ болон нэгж хувьцаа тус бүрийг 1000 дахин хувааж, компанийг нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй нийт 344,000,000 /Гурван зуун дөчин дөрвөн сая/ ширхэг энгийн хувьцаатай болгож өөрчилж, үүнтэй холбоотойгоор компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 болон 4.2 дах хэсэгт өөрчлөлт оруулах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байгаа. Компанийн хувь нийлүүсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй бөгөөд хувь нийлүүсэн хөрөнгийн хэмжээ зөвхөн хувьцааны үнээр буюу 34,400,000 мянган төгрөг хэвээр байх юм.

Хэлэлцсэн асуудалтай холбоотойгоор нэмэлт, өөрчлөлтийг оруулсан “Сүү” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хуралд оролцогчдод танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол саналын хуудсаар саналаа өгцгөөнө үү.

Нарийн бичгийн дарга саналын хуудасны загварыг танилцуулан тарааж өгөв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд: Саналын хуудсаар саналаа өгөв.

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх ёстой байгаа. “Сүү” ХК нь 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн № 29215 тоот “Зээлийн гэрээ”-ний дагуу IFC, BIO, PROPARGO байгууллагуудаас 6,000,000 /Зургаан сая/ ам.долларын зээл авсантай холбогдуулан, энэхүү зээлийн өрийг төлж дуустал буюу 2019 оныг хүртэлх хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх тухай 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн № 01 тоот “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн тогтоол гарсаныг 2015 оны хувьцаа эзэмшигчдын ээлжит хуралд танилцуулсан байгаа. Энэхүү тогтоолын дагуу энэ онд Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй тухай мэдээллийг хүргэж байна.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Ерөнхийдөө гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээний дагуу компани ногдол ашиг тараах үндэслэл, нөхцөл бүрдэж өгөхгүй байгаа юм. Бид ногдол ашиг тараах нөхцөл боломжыг судлаж, хөрөнгө оруулагчдад хүсэлт хүргүүлээд байгаа. Энэхүү хүсэлт нааштайгаар шийдвэрлэгдвэл компанийн зүгээс ногдол ашиг тараах асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудад хүсэлт гаргах юм.

Тогтоолыг уншиж танилцуулав.

Та бүхэнд асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал байгаа.

ТУЗ-ийн Гишүүдийн бүрэн эрхийн хугацааг компанийн дүрэмд заасны дагуу үргэлжлүүлэх, ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамжшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг хэлэлцэнэ.

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдээр дараах нэр бүхий 12 хүн ажиллаж байгааг танилцуулъя. Үүнд:

№	Овог, нэр	Албан тушаал
1	Д.Ганбаатар	ТУЗ-ийн дарга
2	Д.Цэрэнжигмэд	ТУЗ-ийн гишүүн
3	Б.Түвшинтөгс	ТУЗ-ийн гишүүн
4	Д.Жамъян	ТУЗ-ийн гишүүн
5	Ц.Соёл-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн
6	Д.Уянгалянхуа	ТУЗ-ийн гишүүн
7	Б.Гантулга	ТУЗ-ийн гишүүн
8	Н.Бадамханд	ТУЗ-ийн гишүүн
9	Н.Цэрэндорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн
10	Ш.Даваалимбэ	ТУЗ-ийн хараат бус гишүүн
11	Г.Баяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн
12	П.Мэндсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос гаргасан саналын дагуу компанийн ТУЗ-ийн гишүүдэд сар болгон олгох цалин урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоох саналыг ирүүлсэн байгаа.

Уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол саналын хуудсаар саналаа өгцгөөнө үү.

Нарийн бичгийн дарга саналын хуудасны загварыг танилцуулан тарааж өгөв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд: Саналын хуудсаар саналаа өгөв.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Одоо дэгийн дагуу хурал завсарлана. Үүний дараагаар тооллогын комисс тогтоол танилцуулна.

Хурал завсарлав.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Тооллогын комисс тогтоол танилцуулна.

Тооллогын комиссын дарга: Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор, саналын хуудсаар авсан саналуудыг нэгтгэж дүнг гаргалаа. Одоо та бүхэнд дүнг танилцуулая.

“Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д санал хураалтаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар, хэлэлцсэн асуудал тус бүрээр нийт 329,753 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч, хүчингүй санал гараагүй байна.

Эхний хэлэлцсэн асуудал болох “Сүү” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтаар Хуралд оролцсон саналын эрхтэй 329,753 ширхэг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар нийт 329,753 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч, хэлэлцсэн асуудлыг 100% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хоёр дах хэлэлцсэн асуудал болох Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтаар Хуралд оролцсон саналын эрхтэй 329,753 ширхэг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар нийт 329,753 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч, хэлэлцсэн асуудлыг 100% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Дараагийн хэлэлцсэн асуудал болох Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтаар Хуралд оролцсон саналын эрхтэй 329,753 ширхэг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар нийт 329,753 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч, хэлэлцсэн асуудлыг 100% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Дараагийн хэлэлцсэн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх, ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтаар Хуралд оролцсон саналын эрхтэй 329,753 ширхэг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар нийт 329,753 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч, хэлэлцсэн асуудлыг 100% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулан хурал 17:30 цагт хаасныг мэдэгдэв.

Тусгай тэмдэглэл: Байхгүй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН
ХУРЛЫН ДАРГА:



/Д.ГАНБААТАР/

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

/Б.ЦЭРЭНДОРЖ/